

## **Зүүнгарын говийн Монгол болон Дэлхийн дай дахь холбогдол**

Монгол улсын газрын зураг дээр Зүүнгарын говийн дэвсгэр нутаг нь Байтаг Богд, Хавтаг, Тахийн шар нурууг дамнуулан өмнөд этгээдэд БНХАУ-ын Шинжань бүс нутагт хамаарах уудам цөл, говийг дүрсэлсэн байдаг. Үүнээс үзвэл, ихэнх хүмүүс Зүүнгарын говийн бүс нутгийг хилийн чанад дахь “говь” хэмээн ойлгодог. Гэтэл, энэ бүс нутгийн онцлог, байгалийн өвөрмөц төрхийг илэрхийлэх говь, цөл Монгол-Алтайн нурууны өвөрт Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Говь-Алтай аймгийн Тонхил, Бугат сумдын өмнөд нутгийг хамран Монгол, БНХАУ-ын улс төрийн хилийг дамнан оршдогийг мэргэжлийн хүрээний цөөн хүмүүс л мэддэг. Учир нь олон нийтэд энэ тухай цэгцтэй мэдээлэл төдийлөн хүрдэггүй. Харин “Зүүнгар” хэмээх газрын нэрийг монголчууд түүхийн эх сурвалж, ном зохиолоор дамжуулан мэдэх болсон агаад, Монголын эзэнт гүрний түүхэн үед хамааруулан ойлгох нь түгээмэл. Зүүнгарын Хаант улс, Ойрд Монголын нутгийг “Зүүнгарын говь” хэмээн нэрлэж ирсэн түүхэн улбаатай юм. Харин Монгол улсын дэвсгэр нутагт хамаарах Зүүнгарын говь, цөлийн өвөрмөц экосистем, түүний ургамал, амьтны аймгийн онцлог, газарзүйн тогтоц, бүс нутгийн болоод дэлхийн дай дахь байгаль хамгааллын үнэ цэнэ, ирээдүй хойч үед үлдээх өв талаас нь олон үе дамжин идээшин амьдарсан нутгийн иргэд, нийт монголчууд та бүхэнд толилуулж байна.

Зүүнгарын говь, цөл нь Монгол-Алтайн нуруу, түүний салбар Хөвчийн нуруу, Тахийн шар нуруу, Хөх өндөр, Их, Бага Хавтаг, Байтаг Богд, Уушигийн улаан, Гурван хүүхэд зэрэг уул, нуруудаар хүрээлэгдсэн уудам хотгор, дүрсэлвэл үлэмж “тогоо”-ны хэлбэр санагдуулам, Хонин ус, Борж цонж, Баруун хуурай, Давсан хуурай хэмээх хужир, мараалаг хөрстэй цайдам хотгор, одой заган төгөлт тэгш тал, хөндий сунаран оршдог. Дурьдсан цайдам хотгорын булаг, баянбүрд шүтэж тахь, хулан, хар сүүлт зээр, Зүүнгарын даахай, сухайн чичүүл, ногоон бах, толбот гүрвэл, эмгэн шилбэ, саваан азар, Зүүнгарын башир зэрэг нэн ховор, ховор, зөвхөн Зүүнгарын говь, цөлд амьдардаг зарим унаган зүйл амьтан, ургамал, дэлхийн дайдад цөөрч буй аргаль, янгир, ирвэс зэрэг өндөр уулсын хөхтөн, жороо тоодог шувуу байршин амьдардаг. Зөвхөн Булган голын сав газраар Төв Азийн шар минж, ойн унтаахай, тойрмын хонин гүрвэл, шаргал үхэрдэй загас, алтлаг хэлтэг загас тохиолдоно. Энэ нутаг нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Төв Азийн цөлийн их мужийн Зүүнгарын говийн муж (Д.Даш, 2010), хөрс-газарзүйн мужлалаар Зүүнгарын их муж, ургамал-газарзүйн мужлалаар Төв Азийн дэд их мужийн Зүүнгарын муж (З.Санжмятав, 2011)-ид тус тус хамаарна. Харин говийн орон зайн хуваариар Зүүн гарын хотгорт (А.Симуков, 1936), уур амьсгалын хувьд Умард Туранд хамаарах бөгөөд, цаг агаар, хур тунадасны хуваарилалтаар Алтайн өвөр говиос нэлээд ялгаатай (Газарзүйн үндэсний атлас, 2004) ажээ. Шинжлэх ухааны үндэслэлтэй хуваасан мужуудад Зүүнгарын говийг өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бие даасан муж, дэд муж болгон заагласан нь угтаа энэ бүс нутгийг бусад говь, цөлөөс ялган нэрлэж олон нийтэд таниулах, ялангуяа уур амьсгалын хувьд ялгаатай нөхцлийг анхааран орон нутгийн цаг агаарын мэдээгээр тусад нь мэдээлэх шаардлага бий зэрэг олон холбогдолтой болохыг илтгэнэ.

Говийн их дархан цаазат газар /ГИДЦГ/-ын “Б” хэсэгт Зүүнгарын говийн Хонин усны цайдам хотгорыг нийтэд нь, Бор Цонжын говийн зарим хэсгийг хамруулан 927111.8 га талбайтай газар нутгийг 1975 онд Улсын тусгай хамгаалалтад хамруулсан нэг үндэслэл нь

тухайн үед уугуул нутагтаа тахь мөхсөнийг нотолсоны (1972 он) дараа тахийн сүүлчийн сүрэг идээшилж, хааяа үзэгддэг байсан Тахийн шар нуруу, Гүнтамгын ус, Тахийн ус, Тахийн цавчаал зэрэг газрыг оруулжээ. Харин тухайн үед, Зүүнгарын говьд жилийн турш нутаг бэлчээр, ус булаг даган шилжин нүүдэлдэг хулан, хар сүүлт зээрийн зарим идээшил нутгийг гүйцэд хамруулаагүй. Иймд хулан, хар сүүлт зээр, тахийн (1992 оноос сэргээн нутагшуулсан) өвлийн идээшил нутаг Баруун хуурай, Давсан хуурайн цайдам хотгорыг нэмж хамруулах замаар, одоогийн ГИДЦГ-ын “Б” хэсгийн дэвсгэр нутгийг өргөтгөх шаардлагатай юм.Түүнчлэн, зөвхөн Байтаг Богд уулын ар хажууд цөөн газар тохиолддог үндсэн ойгоос алслагдсан арал хэлбэрийн үлдвэр шинэсэн ойн төгөл, шугуйн өвөрмөц амьтан, ургамлын зүйлийн амьдрах орчин, үзэсгэлэнт тогтоцтой газар нутаг болон энэ уулаас умард этгээд рүү буудаг олон булаг, голын голдирол дагуу ургадаг өндөр, шигүү загтай бэлийг тус Дархан цаазат газар /ДЦГ/-ын дэвсгэрт одоогоор хамруулаагүй байна.

Иймд Зүүнгарын говь, цөлийн бүс нутаг нь алт, нүүрс, хар тугалга зэрэг ашигт малтмалаар баялаг хэдий ч ирээдүй хойч үедээ уугуул амьтан, ургамлын хам бүрдэлтэй нь үлдээх “үүц” нутаг тул орон нутгийн санаачлага, БОНХЯ-ны дэмжлэгтэйгээр ГИДЦГ-ын “Б” хэсгийн дэвсгэр нутгийг дээр дурьдсан хамгаалах үндэслэлтэй газруудыг оруулан өргөтгөх ажлыг эхлүүлээд байна. Зарим албан бичиг баримт, бүтээл туурвил, газрын зурагт Говийн их, бага ДЦГ, түүний “А”, “Б” хэсгүүдийг хооронд нь солих, ташаарах, олон нийтийн дунд андуурах тохиолдол түгээмэл байдаг. Мэдээллийн технологи хурдтай хөгжсөн өнөө үед элдэв мэдээллийн эх сурвалж ялгаатай мэдээлэл түгээх болсон нь хүмүүст нэг зүйл, газар нутгийн оноосон нэрийг сольж хутгах, будилах нөхцлийг бүрдүүлж буйг сануулахад илүүдэхгүй болов уу. Тухайлбал, ГИДЦГ-ын “Б” хэсэг хэмээн оноосон нэр нь угтаа өмнө дурьдсан ёсоор түүхийн улбаатай, Монгол орны физик газарзүйн болоод ургамал-газарзүй, амьтны аймгийн мужлалаар Зүүнгарын говь хэмээн нэрлэгддэг учир уг тусгай хамгаалалттай нутгийн нэрийг “Зүүнгарын говийн ДЦГ” хэмээн өөрчлөн нэрлэх шинжлэх ухааны бүрэн үндэслэлтэй.

Зүүнгарын говийн уугуул амьтан тахь, соргог бөхөн зэрэг зүйл өнгөрсөн зууны дунд үед хүмүүс бидний байгаль орчинтойгоо буруу харьцсаны алдаагаар мөхсөн “гашуун түүх”-ийг уншигч танаа нэхэн сануулахад илүүдэх юун.

О.Ганбаатар, Н.Батсайхан

Энэ нийтлэлийг 2013.04.29-ны “Өдрийн сонин”-д нийтлүүлсэн болно.